



ДУНДГОВЬ АЙМАГ  
ДЭЛГЭРЦӨГТ СҮМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 114

Амардалай

Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх  
чиглэлээр авах арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.15-ын "в", 21.1.6-ын "б", Гамшигаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны "Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" А/44 дүгээр захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор сумын шуурхай штабын бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

Хоёр: Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх эрх бүхий аж ахуйн нэгжүүдийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах цагийн хуваарийг 09.00-15.00 цаг хүртэл, суманд үйл ажиллагаа явуулж байгаа эмийн санг хуваарийн дагуу 24.00 цаг хүртэл ажиллуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Шуурхай штаб /3.Наранмандах/, Цагдаагийн хэсэг /Л.Огтлонбаатар/ нарт үүрэг болгосугай.

Гурав: Цагаан сарыг өргөнөөр тэмдэглэхгүй, хот, аймаг, сум дамжин золголт хийхгүй байхыг олон нийтэд өргөн хүрээнд сурталчлах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв: Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт /хэсэгчлэн/ шилжсэнтэй холбогдуулан сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт иргэдийг амны хаалт /маск/ зүүж хэвшихийг үүрэг болгосугай.

Тав: Амны хаалт /маск/-ны хангамж хүрэлцээ хангалтгүй байгаатай холбогдуулан нийт иргэдийг амны хаалт /маск/-ыг ахуйн нөхцөлд оёж гэр бүлийн хэрэгцээг хангах, төр хувийн хэвшлийн байгууллагын удирдлагууд өөрийн байгууллагын ажилтан албан хаагчид болон тэдний гэр бүлийг амны хаалт /маск/-жуулах ажлыг зохион байгуулахыг зөвлөсүгэй.

4880100047